

2017 оны 2р улиралын санхүүгийн үйл ажиллагааны жилийн тайлан

Чойбалсан хот

2017.07.25

“Дорнод Авто зам” Хувьцаат компани нь аймгийнхаа нутаг дэвсгэрт байгаа улсын чанартай 1250 км авто замын арчлалтын хариуцан гүйцэтгэдэг бөгөөд эдгээр замууд нь ОХУ,БНХАУ-тай 7 чиглэлээр холбогддог, улс хоорондын авто замын тээвэрт чухал үүрэг ач холбогдолтой. Халхгол,Нөмрөг Хэллэн Улзын голын ниит 5 бетон хиц бүхий гүүрүүдийн арчлалт хамгаалалтын ажлыг 5 гүүр хамгаалагч хариуцан ажиллаж байна.

Манай компани нь 2017 онд 47.4 сая төгрөгийн борлуулалтын орлого олж, 47.1 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулж 0.3 мянган төгрөгийн ашигтай ажилласан боловч өмнөх онд 19,4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан учраас энэ оны 2р улиралын санхүүгийн тайлангаар хуримтлагдсан ашгийн зөрүү тайлант үе, өмнөх үеийн зөрүүний өссөн дүнгээр 19,1 сая төгрөгийн алдагдалтай гарсан. Тайлант онд Зам,Тээврийн Хөгжлийн Яамтай хийсэн гэрээний дагуу улсын чанартай зам засвар арчлалтын ажлуудыг гэрээний дагуу хийж , ажлын гүйцэтгэл 50 хувьтай явагдаж байна.

Компани дээрхи ажлуудыг хийж гүйцэтгэхдээ 25 ажиллагсадтайгаар зам засвар арчлалтын ажилд ажиллаж, цалингийн зардалд 21,5 сая төгрөг,НДШимтгэл 4.9 сая төгрөг материал түвхий эл худалдан сэлбэг хэрэгсэл болон шатахуунызэрэг шууд үйлдвэрлэлийн зардалд 20,6 сая төгрөгийг зарцуулав. ХААН банкнаас 300,0 сая төгрөгийн зээл авч үйл ажиллагаагаа явуулж байна. Нягтлан бодох бүртгэл хөтлөлтийг НББОУС-ын дагуу хөтлөн, баланс,орлого үр дүнгийн тайлан,өмчийн өөрчлөлтийн тайлан,мөнгөн гүйлгээний тайлан,бусад тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланг бэлтгэн компанийн удирдлагыг санхүүгийн иж бүрэн мэдээлэлээр ханган ажиллаж байна.

Тайлан бичсэн:

“Дорнод Авто зам” Хувьцаат компанийн

Нягтлан бодогч



Ц.ОТГОН